

БАТЛАВ:

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
С.ТӨМӨРХҮҮ

Гамшиг

"АМИНЫ ОРОН СУУЦНЫ ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ  
ТӨВ"-ИЙГ АЖИЛЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024-оны 09 дугаар  
сарын 06-ний өдөр

Дугаар 2024/09

Улаанбаатар хот

д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Төвийг байгуулах үндэслэл	<ul style="list-style-type: none"><li>- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын Зорилт 9.2."Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно." 9-д Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлнэ.</li><li>- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл</li><li>- Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр</li><li>- Шинэ сэргэлтийн бодлого. 5.Ногоон хөгжлийн сэргэлт: 5.4.3.Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарал бага ялгаруулдаг, эрчим хүч, цэвэр усны хэмнэлттэй ногоон төсөл хэрэгжүүлэх,</li><li>- 5.4.4.Ногоон хөгжлийг дэмжих санхүүжилтийн тогтолцоо, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, цэвэр технологийг нутагшуулах</li><li>- Барилгын тухай болон Хот байгуулалтын тухай хууль;</li><li>- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц;</li><li>- Парисын хэлэлцээр, YTXN-ийн зорилт</li><li>- "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1.5-д "Хашаандaa сайхан амьдаръя" хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ", 2.4.1.6-д "Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ", 2.4.1.7-д "Гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ" гэж тус тус заасанг хэрэгжүүлэх зорилгоор иргэд амины орон сууцны талаарх цогц зөвлөгөө мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх "Амины орон сууцны технологи дамжуулах төв"-ийг барьж байгуулах болон үйл ажиллагааг зохион байгуулна.</li></ul>
2.	Төвийн зорилго, хамрах хүрээ	Дээрх бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын шаардлагад нийцсэн, дэвшилтэт технологи бүхий нэг айлын орон сууцны зураг төсөл, материал, технологи, тоног төхөөрөмж, үйлдвэрлэл, угсралт зэрэг үйл ажиллагааны цогц мэдээллийг нэг цонхны үйлчилгээгэр дамжуулан иргэд, олон нийтэд танилцуулах, сурталчлах, хямд өртөг бүхий амины орон

		<p>сууцыг барих, ипотекийн зээлд хамрагдах боломжийг таниулах, сургах, зөвлөгөө мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн төвийг байгуулах зорилготой.</p> <p>Төвийн үйл ажиллагааны хамрах хүрээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинэ технологи, инновац дамжуулалт, нутагшуулалт;</li> <li>• Тархмал эх үүсвэр ашиглах туршилт, тооцоолол;</li> <li>• Зураг төсөл, тооцоолол;</li> <li>• Барилгын материал үйлдвэрлэл;</li> <li>• Бараа материал ханган нийлүүлэлт,</li> <li>• Хөрөнгө оруулалт, банк санхүү;</li> <li>• Сургалт, судалгаа, контент;</li> <li>• ЭХХ-тэй амины орон сууц, технологийн онцлог, ашиглалтын зааварчилгаа, зөвлөгөө,</li> <li>• Барилгын явцын хяналт;</li> <li>• Мэдээллийн сан;</li> </ul>
3.	Шийдвэрлэх асуудал	<p><b>1. Төвийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулна.</b></p> <p>Үг төлөвлөгөөнд заавал тусгах үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн хүрээнд баригдсан Загвар амины сууцнуудын байнгын үйл ажиллагааг хэрхэн хариуцах, сурталчлах, технологийг танилцуулах, зохион байгуулах,</li> <li>- Сургалтын зохион байгуулах. Сургалтын төрөл: <ul style="list-style-type: none"> <li>- Амины орон сууц барих ААН-д зориулсан,</li> <li>- Амины орон сууцтай болох хүсэлтэй иргэдэд зориулсан, /анхан шатны, арчлалт ашиглалтын г.м/</li> <li>- Хэрхэн хямд өртөгтэй АОС-тай болох,</li> <li>- Амины орон сууц барих мэргэжилтэй ажилчдыг чадавхжуулах г.м.</li> </ul> </li> <li>- Сургалтын хөтөлбөр боловсруулах, багшлах, тараах материал бэлтгэх,</li> <li>- Хамтран ажиллах Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, оролцоо,</li> <li>- Технологи, инновац дамжуулах арга хэмжээ,</li> <li>- Судалгаа, тооцоолол хийх,</li> <li>- Хамтран ажилладаг Хөрөнгө оруулагч, даатгал, банк санхүүгийн байгууллага, оролцоо,</li> <li>- Барилгын явцын хяналт хийх, баталгажуулах,</li> <li>- Хамрах хүрээнд заагдсан бусад үйл ажиллагаа.</li> </ul> <p><b>2. Мэдээллийн сантай байна.</b> Мэдээллийн сан нь дараах агуулга, бүтэцтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Амины орон сууцны загвар зураг төслүүд /магадлал хийгдсэн, 50-аас багагүй тоо ширхэгтэй, каталог үүсгэх боломжтой байх/;</li> <li>- Амины орон сууц барьдаг ААН, үйлдвэрлэгч, нийлүүлэгч нарын бүртгэл, холбогдох мэдээлэл;</li> <li>- Амины орон сууцанд нэвтрүүлж, ашиглаж буй хаших хийц, бүтээц эдлэхүүн, халаалт, дулаалга, хөргөлт, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, сэргээгдэх эрчим хүч, саарал усны хэрэглээ, хог хаягдал, ногоон байгууламж, материал үйлдвэрлэл, орчны бохирдол, ногоон санхүүжилт, сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагааны мэдээлэл;</li> <li>- Шинэ техник, технологийн хэрэглээний талаарх мэдээлэлд тулгуурлан манай орны нөхцөлд хэрэглэх, нутагшуулах боломжтой талаарх төрөл бурийн судалгаа, мэдээлэл;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээ хийх байгууллага /хяналт хийх аудит, экспертуудийн тоо, бүтэц, чадавхын талаар/ мэдээлэл;</li> </ul> <p><b>3.Шаардлагад нийцсэн амины орон сууц, түүнд тавигдах шаардлагын дагуу баригдсан эсэхийг үнэлэх, хяналт тавих, зээл олгох шаардлагад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.</b> Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээ хийх, хяналт тавих байгууллага /хяналтын бүтэц, орон тоо,чадавхын талаар/;</li> <li>• Салбарын төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагаа;</li> <li>• Үнэлгээ, хяналт тавихад цахим систем ашиглах,</li> <li>• Шаардлагад нийцүүлсэн зээлийн хүсэлт, олгосон зээлийн хэмжээ, мэдээлэл /банк, санхүүгийн байгууллагын мэдээлэл, тавигдах шаардлага/.</li> </ul> <p><b>4.Холбогдох зардлын тооцоог гаргасан байна.</b></p> <p><b>5.Батлагдсан даалгаварын дагуу төслийн бурдэлийг захиалагчид хүлээлгэн өгнө.</b></p>
4.	Төслийн бурдэл	<ol style="list-style-type: none"> <li>1. Төвийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө</li> <li>2. Үйл ажиллагааны зардлын тооцоо</li> <li>3. Багийн бүрэлдэхүүн</li> <li>4. Мэдээллийн сан, түүний агуулга</li> </ol>
5.	Төслийн үр дүн	"Амины орон сууцны технологи дамжуулах төв"-ийг байгуулж, ажиллуулснаар амины орон сууцны үйл ажиллагааны цогц мэдээллийг нэг цонхны үйлчилгээгээр авах болон олон нийтэд сурталчлах, иргэд өөрсдөө хямд үнээр амины орон сууцаа сонгон барих, эрчим хүчний хэмнэлттэй шинэ, техник технологийг ашигласан амины орон сууцаа үр ашигтай ашиглах, амьдрах болон ногоон, ипотекийн зээлд хамрагдах боломжийг сурталчлан, зөвлөгөө мэдээлэл өгөх, мэргэжилт арга зүйн туслалцаа үзүүлж амины орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн байна. Агаар, хөрсний бохирдолыг бууруулахад хувь нэмэр оруулж, орон нутагт төвүүдийг ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.
6.	Захиалагч байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
7.	Гүйцэтгэгч хуулийн этгээд	Гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгоно.
8.	Дуусах хугацаа	2024 оны 4-р улирал
9.	Үргэлжлэх хугацаа	1 жил
10.	Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ	Нийт 98 000 000 төгрөг /ерэн найман сая/-ийг Улсын төсвийн урсгал зардлаас санхүүжүүлнэ.
11.	Онцгой нөхцөл	<ol style="list-style-type: none"> <li>1. Төвийг байгуулах байртай бөгөөд өөрийн эсхүл урт хугацааны түрээсийн гэрээтэй байх,</li> <li>2. Тус байр нь хүрэлцэхүйц авто зогсоолтой байх /30 машинаас доошгүй/, showroom байрлуулах боломжтой байх;</li> <li>3. Байнгын ажилчид, хүний нөөц бүхий баг бүрдүүлсэн байх /хүний тоо/;</li> <li>4. Олон улсын болон Монгол улсын хууль, дүрэм, журам, стандартад нийцүүлсэн үйл ажиллагаа явуулна.</li> <li>5. Төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагатай хамтран үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой байна.</li> </ol>

		<p>6. Гадаадын байгууллагатай хамтран ажиллах, санхүүгийн дэмжлэг авахыг хориглохгүй.</p> <p>7. Төлөвлөгөө нь ажлын даалгаварын бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төвийн байршил, үйл ажиллагаа, зохион байгуулалтын онцлогоос хамааран нэмэлт мэдээлэл тусгах, сайжруулалт хийх, өөрчлөлт орж болно.</p>
--	--	---

**ХЯНАСАН:**

ХББОСЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН  
МАТЕРИАЛЫН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ГАНТУЛГА

ХББОСЯ-НЫ ЯАМНЫ САНХҮҮ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Ц.АРИУНСАНАА

ХББОСЯ-НЫ ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БАТБОЛД

ХББОСЯ-НЫ САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.МӨНГӨНЦЭЦЭГ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХББОСЯ-НЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ,  
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.БОЛОРМАА

ХББОСЯ-НЫ БАРИЛГА, БАРИЛГЫН  
МАТЕРИАЛЫН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Б.ГАНДОЛГОР